МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 22 өдөр Дугаар А/39 Мандалговь

Тусгай зөвшөөрлийн эрх
олгох, сунгах, хүчингүй болгох тухай

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.2, 7.4, 9 дүгээр зүйлийн 9.1.2, 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалт, "Архидан согтуурахтай тэмцэх тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 4.7 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2, 6.3 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.7, 7.1.8, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Татварын хэлтэст бүртгэлтэй Мэнгэт баянбулаг, Баянбулаг мандал, Мандалын говийн хурд, Чандмань норовлингаа ХХК-ны хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр хүртэлх хугацаагаар сунгасугай.

Хоёр. Сайнцагаан сумын Анут хийморь трейд, БМБХ, Үүдэн цахир ХХК-ны тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр хүртэлх хугацаагаар олгосугай.

Гурав. Адаацаг сумын Санжаасүрэн ХХК-ны караоке барны архи, согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх , Хулд сумын Олдохын жандмань ХХК-ны хүнсний дэлгүүрийн архи, согтууруулах ундаа худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр хүртэлх хугацаагаар сэргээн олгосугай.

Дөрөв. Сайнцагаан сумын татварын албанд бүртгэлтэй Силвер кров ХХК-ны зоогийн газар, Мандалын говийн хурд ХХК-ны Хөрх булаг ХХК-ны худалдаа үйлчилгээний төвд байрлалтай хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрлийн эрхийг 2021 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөс хүчингүй болгосугай.

Тав. Мэнгэт баянбулаг, Баянбулаг мандал, Мандалын говийн хурд, Анут хийморь трейд, БМБХ, Үүдэн цахир ХХК-ны хүнсний дэлгүүр, Санжаасүрэн ХХК-ны караоке барны ажиллах цагийн хуваарийн хязгаарыг $08^{00}$ -$24^{00}$, Чандмань норовлингаа, Олдохын жандмань ХХК-ны худалдааны газруудын ажиллах цагийн хуваарийн хязгаарыг $09^{00}$-$21^{00}$ цаг хүртэлх хугацаагаар тус тус батлсугай.

Зургаа. Гарсан шийдвэрийг холбогдох газруудад хуулийн хугацаанд мэдэгдэхийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), тухайн аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Татварын хэлтэс (М.Туяацэцэг), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

481210064